

## Стивтэй танилцана уу



AMEP хөтөлбөр Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний мэргэжилтэн Стив Гемеллтэй та бүхнийг танилцуулж буйдаа баяртай байна. Гемелл Австрали улсаас гадна, Америк, Африк, Ази, Европт ивд уурхайн инженерээр ажилласан 40 жилийн туршлагатай. Тэрээр одоо Олон улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний хорооны даргаар ажилладаг. Стив, “Би Улаанбаатарт ирсэндээ тун баяртай байна. МУ-ын ЗГ, эрдэс баялгийн салбар, хувийн хэвшлийн төлөөлөлтэй уулзаж, хамтран ажиллах болсондоо таатай байна” гэсэн юм.

Гемелл МУ-ын Санхүүгийн зохицуулах хорооны удирдан явуулж буй Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний код боловсруулах ажлын хэсэгт зөвлөн ажиллаж байна.

Тэрээр мөн 2019 оны 11, 12 дугаар сард олон улсын хөрөнгийн үнэлгээний кодын талаар цуврал сургалт, танилцуулга явуулж байна.

2019-20 онд АМЕП-аас хэрэгжүүлж байгаа зургаан ажлын нэг нь Ашигт малтмалын үнэлгээний код боловсруулахад Монголын ЗГ-ын хамтрагч байгууллагуудад туслалцаа үзүүлэх төсөл юм. Тус кодыг Канад, Австрали, Өмнөд Африкийн үнэлгээний кодын адил олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц байх талаас нь бид анхааран ажиллаж байна. Энэ удаагийн мэдээллийн товхимолдоо бид хөрөнгийн үнэлгээ гэж юу болох, МУ-д яагаад чухал, мөн олон улсын хөрөнгө оруулалтыг татахад ямар ач холбогдолтой талаар танилцуулъя.

## Ашигт малтмалын хөрөнгө үнэлэх гэж юу вэ?

Тухайн цаг үед орд газар ямар үнэ хүрэхийг мөнгөн дүнгээр илэрхийлэх үйл явцыг ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ гэж 2015 онд батлагдсан ВАЛМИН кодын 14 дүгээр зүйлд тодорхойлжээ.

## Үнэлгээ хийхийн ач холбогдол

1. Ашигт малтмалын хөрөнгө худалдан авах, зарж борлуулах ханш тогтоох
2. Хөрөнгө оруулалтын өөр хувилбарууд судлах
3. Компани хоорондоо нэгдэх, нэг нь нөгөөгөө худалдан авах тохиолдолд хувьцаа эзэмшигч, оролцогч талуудад зөвлөх
4. Суурь татвар, хураамжийн хэмжээ тогтоох
5. Компанийн санхүүгийн тооцоонд хөрөнгийн хэмжээг тоон дүнгээр илэрхийлэх
6. Хамтарсан үйлдвэр, үйл ажиллагааны оролцооны түвшинг тодорхойлох
7. Нэмэлт эрэл хайгуул хийснээр хөрөнгийн үнэ цэнийг өсгөх боломжтой эсэхийг шинжилж дүгнэх.

## Яагаад Монголд хэрэгтэй вэ?

Орд газрын зах зээлийн үнийг мөнгөн дүнгээр тооцож гаргах нь маргаантай, мөн урт удаан хугацааны хэлэлцээр болох нь түгээмэл. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хөрөнгийн үнэлгээний код нь ЗГ, компани хоорондын хэлцлийн үйл явцыг илүү үр дүнтэй, ил тод, шударга болгож, мөн ЗГ, хөрөнгийн бирж, хөрөнгө оруулагчдад зориулсан тайлан тооцоог найдвартай болгодог.

Стандартын дагуу бэлдсэн хөрөнгийн үнэлгээний тайлан нь итгэлцэл, найдвартай байдлыг нэмэгдүүлэхээс гадна эрх зүйн өөр тогтолцоо бүхий улс хооронд хөрвөх чадамжийг өсгөнө. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний код мөн үндэсний уурхайн компаниуд олон улсын зах зээлд гарах, гадаадын хөрөнгө оруулагчдыг Монголд татах боломжийг нээнэ.

# Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний код гэж юу вэ?

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого 2014-т МУ ашигт малтмалын нөөц, ордын хөрөнгийг үнэлэхдээ олон улсын туршлага нэвтрүүлэх зорилго тавьсан. МУ 2014 онд мөн Эрдэс баялаг, хүдрийн нөөцийг олон нийтэд мэдээлэх Монгол улсын код батлан гаргасан бөгөөд энэ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн код юм. Энэ код дээр үндэслэн, хөрөнгийн үнэлгээний код боловсруулагдана.

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний код гэдэг нь эрдэс баялаг, орд газрыг мөнгөн дүнгээр үнэлэхэд хөндлөнгийн мэргэжилтний дагаж мөрдөх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тооцоо судалгааны арга аргачлал, зарчим юм. Олон улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний хороо ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ хийх загвар батлан гаргасан. Австрали, Канад, Өмнөд Африк, АНУ энэ хорооноос гаргасан хөрөнгийн үнэлгээний тодорхойлолт, үнэлгээ хийх зарчмыг баримталсан тус тусын кодтой. Монгол улс ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодоо олон улсын стандартад нийцүүлэн хийх бөгөөд энэ код нь Эрдэс баялаг, хүдрийн нөөцийг олон нийтэд тайлагнах МУ-ын кодтой хамт хэрэглэгдэнэ.

## Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг хэн хийдэг вэ?

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн үнэлгээний кодын тулгуур зарчим нь хөндлөнгийн үнэлгээний мэргэжилтэн юм. Мэргэжлийн ёс зүйн кодын дагуу хариуцлага хүлээхэд бэлнээ илэрхийлсэн, туршлагатай, мэдлэг чадвартай мэргэжилтний бэлтгэсэн хөрөнгийн үнэлгээний тайланг олон улсад хүлээн зөвшөөрдөг. Үнэлгээчин нь үнэлгээ хийж буй ашигт малтмалын төрлөөрөө дагнасан, мэргэжил нэгтнүүддээ ур чадвар, мэдлэгээ батлан харуулсан, зах зээл, үнэлгээний ажлын зорилго зорилтоо сайтар ойлгосон байх ёстой. Монголын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодын дагуу үнэлгээ хийх мэргэжилтнүүдийг магадлан итгэмжлэх, хариуцлага хүлээлгэх мэргэжлийн холбоог тодорхойлох хэрэгцээ байна.



-- МАНАЙ ЗОРИЛТ:

Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар МУ-ын эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад хувь нэмэр оруулах